



УСНЫ САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭДЭГ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН УДИРДЛАГАТАЙ ЦАХИМ УУЛЗАЛТ ХИЙВ



Монголын МСС-аас Компакт гэрээний санхүүжилтээр барьж байгуулах усны салбарын шинэ дэд бүтэц, үйлдвэрүүдэд ажиллах хүчнийг бэлтгэх асуудлаар Монгол Улсад усны салбарын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн төлөөлөлтэй цахим уулзалт зохион байгууллаа. Уулзалтад ШУТИС-ийн Барилга архитектурын сургуулийн Хүрээлэн буй орчны инженерийн салбарын эрхлэгч С.Чулуунхуяг, МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн Хүрээлэн буй орчин ба ойн инженерчлэлийн тэнхимийн эрхлэгч Ч.Сономдагва, Монгол-Германы хамтарсан ашигт

малтмал, технологийн их сургуулийн (МГТИС) захирал Б.Батцэнгэл, тус сургуулийн Хүрээлэн буй орчны инженерийн сургалтын хөтөлбөрийн зохицуулагч Дэд профессор Г.Гантуяа, Хүрээлэн буй орчны инженерийн багш, доктор Ц.Ариунтуяа болон холбогдох мэргэжилтнүүд, Монголын МСС-аас Гүйцэтгэх захирал Э.Содонтогос, Баруун эх үүсвэрийг байгуулах төслийн захирал Б.Батсүх, Хаягдал ус дахин боловсруулах төслийн захирал Т.Хишигт, Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн мэргэжилтэн Т.Цэнгүүн нар оролцов. Уулзалтаар Монголын МСС-ийн зүгээс Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд барьж байгуулах Ус гүн цэвэршүүлэх байгууламж, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг танилцуулснаас гадна усны салбарын мэргэжилтэн бэлтгэдэг сургалтын хөтөлбөр, салбарын хүний нөөцийн өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл авч, санал солилцлоо...

Эх сурвалж: Монголын МСС

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ АШИГЛАЛТАД ОРЛОО

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд есөн аймгийн Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажил хийгдэж байгаа бөгөөд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж дууссан байна. Төслийн үр дүнд Хөвсгөл аймгийн төвд хоногт 3000 м3 хүчин чадалтай, байгаль орчинд ээлтэй орчин үеийн биологи цэвэрлэгээний бохир ус цэвэрлэх байгууламж баригдаж, цэвэрлэсэн усаа ногоон байгууламж, зам талбай услахад дахин ашиглах, цэвэрлэх байгууламжаас гарч буй лагийг боловсруулж шахмал түлш гарган авах нөхцөл бүрджээ. Шинээр барьсан Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн авч явах ашиглалтын байгууллага болох “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 22 ажилтныг онолын болон танилцуулах сургалтад хамруулж, ажиллуулж байна. Барилга, байгууламжийг ашиглалтад хүлээж авсан өдрөөс эхлэн цэвэрлэх байгууламжийн туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажил 1 жилийн хугацаанд үргэлжлэх аж.

Эх сурвалж: БХБЯ

ЦЭНГЭГ УСГҮЙ ИРЭЭДҮЙД БЭЛЭН ҮҮ?

2014 онд АНУ-ын их сургуулиуд болон Монгол улсын их сургуулийн эрдэмтэд хамтарч “Том, алслагдсан, уулархаг нутгийн нуурууд дахь бичил хуванцрын бохирдол” судалгааг хийжээ. Уг судалгаанд Монгол Улсын цэнгэг усны нөөцийн 70%, дэлхийн цэнгэг усны нөөцийн 1%-ийг агуулдаг “Хөвсгөл нуур” багтсан байна. Судалгаагаар бичил пластик болон Хөвсгөл нуурын эргийн дагуух хог хаягдлын тоон үзүүлэлтийг гаргажээ. Хөвсгөл нуурын судалгаа хийгдсэн хэсгийн микропластикийн нягтшил км2 тутамд 997-44,435 хооронд хэлбэлзэж байсан ба энэ нь дунджаар нэг км2-д 20,264 ширхэг микропластик байна гэсэн үг юм. Судалгаанд хамрагдсан бусад нууруудтай харьцуулбал хамаагүй их тоо юм. Хуванцрын хэлтэрхий, гялгар уутны сэмэрхий, мяндсан утас зэрэг гэр ахуйн хүрээнд өргөн хэрэглэгддэг микропластикууд хамгийн ихээр олдсон байна. 5мм-ээс жижиг хэмжээтэй пластикийг микропластик гэдэг. Микропластик нь хоёр төрөлтэй. Нэг нь “primary” буюу “анхдагч” микропластик. Нөгөөх нь “secondary” буюу “хоёрдогч”. Энэ нь энгийн хэмжээтэй пластикаас эмтэрч бутарсаар 5мм-ээс жижиг хэмжээтэй болсон тохиолдлыг хэлнэ. Энэ төрлийн пластик хамгийн аюултай ба бараг хэзээ ч үгүй болохгүй, жижгэрсээр шувуу, загасны “хоол” болж, бид бүгдийн ундаалах усанд орж экосистемд ихээхэн хохирол учруулдаг...

Эх сурвалж: gogo.mn

ТОВЧХОН



АНУ-ын Калифорни мужийн Нийгмийн эрүүл мэндийн мэргэшсэн мэргэжилтэн Д.Юмчиндорж: “Миний амьдарч буй дүүрэгт намгийг маш сайн хамгаалдаг нь ундны усыг барьдаг чухал ач холбогдолтой. Намагтай газрууд нь байнгын хяналттай байдаг. Харин Монголд сүүлийн үед намаг, булаг шандын ойролцоо маш их орон сууцны хороолол, амины орон сууц барих болсон гэж хардаг. Хэрэв намган дээрээ барилга барьсаар байвал цаашид усгүй болох эрсдэлтэй. Өнөөдөр бид болж байгаа ч цаашид яах вэ, ирээдүйгээ бодох ёстой” [Эх сурвалж: news.mn](#)

Стокгольмын Олон улсын усны хүрээлэн жил бүрийн уламжлал болсон Дэлхийн усны долоо хоногийн арга хэмжээгээ энэ жил наймдугаар сарын 23-27-ны өдрүүдэд дижитал хэлбэрээр зохион байгуулна. Усны салбарынхны хамгийн том цугларалтын нэгд тооцогддог энэхүү арга хэмжээний мэдээллийг дэлгэрэнгүйг [энэ холбоосоор](#) авч, мөн бүртгүүлэх боломжтой. [Эх сурвалж: Worldwaterweek.org](#)